

2024 он 7 сар 4 өдөр

Дугаар 10/24

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирлын албан
тушаалд нэр дэвшүүлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь хэсэг, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйл, 55.1, 55.2 дахь хэсэг, Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хорооны 2024 оны 6 сарын 19-ны өдрийн хурлаас гарсан зөвлөмж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 7 сарын 4-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Намдалдагва овогтой Эрдэнэтулгыг “Ард даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд нэр дэвшүүлж Санхүүгийн Зохицуулах Хороонд “Эрх бүхий албан тушаалтан” томилох хүсэлтийг гаргасугай.
2. Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Эрх бүхий албан тушаалтныг томилох” зөвшөөрөл гарсан өдрөөс Намдалдагва овогтой Эрдэнэтулгыг “Ард даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсонд тооцсугай.
3. Гүйцэтгэх захиралтай “Онцгой нөхцөлт бүхий хөдөлмөрийн гэрээ” байгуулж ажиллахыг ТУЗ-ийн дарга О.Одбаярт даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Санхүүгийн Зохицуулах Хороонд тохиромжтой этгээдээр бүртгүүлэх, Улсын бүртгэлийн байгууллагад Гүйцэтгэх захиралын өөрчлөлтийг бүртгүүлэхийг хуульч (Г.Хонгор)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

ДАРГА



О.ОДБАЯР